

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

ИЛТГЭХ ХУУДАС

“Дүүргийн дэргэдэх байгууллагуудад
шалган, зөвлөх ажил зохион байгуулсан тухай ”

2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр

Улаанбаатар хот

Нэг. Удирдлага зохион байгуулалт

Дүүргийн Засаг даргын 2025 оны А/193 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг нь Монгол Улсын Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн хяналт, шалгалтын тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам” батлах тухай 311 дүгээр тогтоол, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100, 2023 оны 98 дугаар тушаал, дүүргийн Засаг даргын 2025 оны А/18 дугаар захирамж болон холбогдох эрх зүйн актуудыг удирдлага болгон ажиллав.

Хоёр. Хяналт шалгалтын талаар

Дүүргийн Засаг даргын 2025 оны А/193 дугаар захирамжаар баталсан удирдамжийн дагуу дүүргийн Нийгмийн даатгалын газар, Татварын хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсүүдийн өдөр тутмын үйл ажиллагааг шалган, зөвлөх ажлыг 2025 оны 04 дүгээр сарын 03-16-ны өдрүүдэд зохион байгуулан ажиллалаа.

Шалган, зөвлөх ажлыг гүйцэтгэхдээ

1. Төсөв, санхүүгийн ил тод байдал, улс нийслэл дүүргийн орлогын гүйцэтгэл, тайлагнал
2. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан (Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаал)
3. Төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан (Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаал)
4. Дүүргийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөний мэдээллийг ажилтан албан хаагчдад хүргэсэн байдал, шуурхай хуралдааны бүрдэл
5. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт
6. Ирсэн бичгийн шийдвэрлэлт

7. Дүүргийн Засаг даргын 01 албан даалгаврын хэрэгжилт гэсэн шалгуур үзүүлэлтээр байгууллагын дотоод үйл ажиллагаатай танилцаж, заавар зөвлөмж өгч ажилласан.

Гурав. Дүгнэлт

Шалган, зөвлөх ажлын хэсгээс дээрх 4 байгууллагын дотоод үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай гэж үзэн Зөвлөмж боловсруулан хүргүүлээ.

ТАНИЛЦСАН:

ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН

ДАРГА



С.ТУУЛМАА

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН

МЭРГЭЖИЛТЭН  О.ЯНЖИНЛХАМ

Шалган зөвлөх ажлын зураг

